



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/50

Арвайхээр сум

Сургалтын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрлийг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.4, Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Санал дүгнэлт хргүүлэх тухай” 18 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Арвайхээр сумын 10, 11 дүгээр цэцэрлэг, Хархорин сумын 4, 5 дугаар цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2023 оны 2 дугаар сарын 06-ны өдрөөс 2028 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хүртэл тус тус 5 жилийн хугацаатай сунгасугай.

2.Сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгагдсан дээрх байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газар (Н.Чимэддорж-Ойдов)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0108